



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 09 өдөр

Дугаар A/116

Батноров сум

Газар эзэмшүүлэх хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг сунгуулах тухай нотлох баримтыг бүрдүүлэн хүсэлт гаргасны дагуу “Ваёо эстэйт” ХХК-ны Идэрмэг 5 дугаар багийн нутаг Дэлгэрхаан нэртэй газарт байрлах уул уурхайн ашиглалт, олборлолт явуулах зориулалттай 2304011700 нэгж талбарын дугаар бүхий 573413 квадрат метр газрын эзэмших хугацааг 166А тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлттэй уялдуулан 20 жилийн хугацаагаар сунгасугай.

2.Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, Газрын тухай хууль болон гэрээнд заагдсан заалтуудын дагуу эзэмшихийг “Ваёо эстэйт” ХХК-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Э.Зулцэцэг)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны А/100 тоот захирамж, 207804 тоот газар эзэмших эрхийн гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

ДАРГА



ГОТГОНБАЯР

232530009